

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүмбэр сумын "Орон нутгийн хөгжлийн сан"-гийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ГСА-2022/04/СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Чойр хот  
2022 он

Тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа  
Утас: 70543156  
Цахим хаяг: [sarantuyab@audit.gov.mn](mailto:sarantuyab@audit.gov.mn)

Аудитын менежер: Г.Наранбаяр  
Утас: 70543179  
Цахим хаяг: [naranbayarg@audit.gov.mn](mailto:naranbayarg@audit.gov.mn)

Аудитор: Б.Анхтуяа  
Утас: 70543179  
Цахим хаяг: [ankhtuyab@audit.gov.mn](mailto:ankhtuyab@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Товчилсон үгийн жагсаалт**

АИТХ	Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МУЕА	Монгол улсын Ерөнхий аудитор
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг

Утас/Факс: 976-7054 3179

И-мэйл: goviusumber@audit.gov.mn

СҮМБЭР СУМЫН "ОРОН НУТГИЙН  
ХӨГЖЛИЙН САН"-ГИЙН ТӨСВИЙН  
ЗАХИРАГЧ Т.БАТ-ЭРДЭНЭ ТАНАА

2022.02.25 № 47  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сүмбэр сумын "Орон нутгийн хөгжлийн сан"-гийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит-хийлээ.

Сүмбэр сумын "Орон нутгийн хөгжлийн сан"-гийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

008020145

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *Б.Сарантуяа* Б.САРАНТУЯА

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /			
Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>149,106,464.59</b>	<b>142,643,338.59</b>
31	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>142,856,464.59</b>	<b>142,643,338.59</b>
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	142,856,464.59	142,643,338.59
31210	Төгрөг	142,856,464.59	142,643,338.59
31211	Төрийн сангийн харилцах	142,856,464.59	142,643,338.59
33	<b>АВЛАГА</b>	<b>6,250,000.00</b>	<b>0.00</b>
33500	<b>Бусад авлага</b>	<b>6,250,000.00</b>	<b>0.00</b>
33510	Байгууллагаас авах авлага	6,250,000.00	0.00
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>149,106,464.59</b>	<b>142,643,338.59</b>
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>149,106,464.59</b>	<b>142,643,338.59</b>
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>149,106,464.59</b>	<b>142,643,338.59</b>
51200	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>149,106,464.59</b>	<b>142,643,338.59</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	57,442,546.59	149,106,464.59
51220	Тайлант үеийн үр дүн	91,663,918.00	-6,463,126.00
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>149,106,464.59</b>	<b>142,643,338.59</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/ төгрөгөөр /			
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>451,105,400.00</b>	<b>519,818,500.00</b>
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>451,105,400.00</b>	<b>519,818,500.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>171,105,400.00</b>	<b>244,818,500.00</b>
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	171,105,400.00	244,818,500.00
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>280,000,000.00</b>	<b>275,000,000.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	280,000,000.00	275,000,000.00
II	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>359,441,482.00</b>	<b>526,281,626.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>359,441,482.00</b>	<b>526,281,626.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>359,441,482.00</b>	<b>526,281,626.00</b>

"Сүмбэр сумын Орон нутгийн хөгжлийн сан"-гийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2104	Хангамж, бараа материалын зардал	321,901,182.00	432,450,166.00
210409	Бараа материал шилжүүлсний зардал	321,901,182.00	432,450,166.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,266,000.00	8,266,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,266,000.00	8,266,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	29,274,300.00	85,565,460.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	29,274,300.00	85,565,460.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	91,663,918.00	-6,463,126.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	91,663,918.00	-6,463,126.00

**2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээхр үлдэгдэл	0.00	0.00	57,433,837.58	57,433,837.58
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	8,709.01	8,709.01
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	57,442,546.59	57,442,546.59
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
7	Өмчид гарсан өөрчилөлт	0.00	0.00	0.00	0.00
8	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	91,663,918.00	91,663,918.00
10	2020 оны 12-р сарын 31-нээхр үлдэгдэл	0.00	0.00	149,106,464.59	149,106,464.59
11	2021 оны 1-р сарын 1-нээхр үлдэгдэл	0.00	0.00	149,106,464.59	149,106,464.59
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	149,106,464.59	149,106,464.59

**"Сүмбэр сумын Орон нутгийн хөгжлийн сан"-гийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
17	Өмчид гарсан өөрчилөлт	0.00	0.00	0.00	0.00
18	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-6,463,126.00	-6,463,126.00
20	<b>2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>142,643,338.59</b>	<b>142,643,338.59</b>

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Код	Үзүүлэлт	/ төгрөгөөр /	
		ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>451,105,400.00</b>	<b>519,818,500.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>451,105,400.00</b>	<b>519,818,500.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>171,105,400.00</b>	<b>244,818,500.00</b>
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	171,105,400.00	244,818,500.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>280,000,000.00</b>	<b>275,000,000.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	280,000,000.00	275,000,000.00
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>37,540,300.00</b>	<b>93,831,460.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>37,540,300.00</b>	<b>93,831,460.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>37,540,300.00</b>	<b>93,831,460.00</b>
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>8,266,000.00</b>	<b>8,266,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,266,000.00	8,266,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>29,274,300.00</b>	<b>85,565,460.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	29,274,300.00	85,565,460.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>413,565,100.00</b>	<b>425,987,040.00</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>308,984,888.00</b>	<b>426,200,166.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>308,984,888.00</b>	<b>426,200,166.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>308,984,888.00</b>	<b>426,200,166.00</b>

"Сүмбэр сумын Орон нутгийн хөгжлийн сан"-гийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

223001	Бусад хөрөнгө	308,984,888.00	426,200,166.00
VI	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-308,984,888.00</b>	<b>-426,200,166.00</b>
VIII	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>104,580,212.00</b>	<b>-213,126.00</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	38,276,252.59	142,856,464.59
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	142,856,464.59	142,643,338.59

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>659,818,500.00</b>	<b>520,031,626.00</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	98,355,800.00	93,831,460.00
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>98,355,800.00</b>	<b>93,831,460.00</b>
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>8,266,000.00</b>	<b>8,266,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,266,000.00	8,266,000.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>90,089,800.00</b>	<b>85,565,460.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	90,089,800.00	85,565,460.00
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>561,462,700.00</b>	<b>426,200,166.00</b>
223001	Бусад хөрөнгө	561,462,700.00	426,200,166.00
III	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>659,818,500.00</b>	<b>519,818,500.00</b>
31	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>244,818,500.00</b>	<b>244,818,500.00</b>
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	244,818,500.00	244,818,500.00
32	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>275,000,000.00</b>	<b>275,000,000.00</b>
320001	Орон нутгийн төсвөөс	275,000,000.00	275,000,000.00
35	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>140,000,000.00</b>	<b>0.00</b>
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	140,000,000.00	0.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	142,856,464.59
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	142,643,338.59



### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу "Сүмбэр сумын Орон нутгийн хөгжлийн сан"-гийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдтэй холбоотой цахим татварын системээр зарлагын гүйлгээг тулгаж байх талаар зөвлөмж өгсөн байна.

Аудитыг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Анхтуяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Наранбаяр, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Сарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүмбэр сумын "Орон нутгийн хөгжлийн сан" нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн А/64 дугаар албан бичгээр хуульд заасан хугацаанд ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

"Сүмбэр сумын Орон нутгийн хөгжлийн сан"-гийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ.

- Орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн тэнцвэртэй байдлыг хангах зорилгоор орон нутгийн төсвөөс санхүүжүүлэгдсэн хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ

Тайлант хугацаанд байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Тухайлбал: Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам", Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар" тус тус шинэчлэгдэн батлагдсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Санхүү, хяналт аудитын алба 2021 онд "Сүмбэр сумын Орон нутгийн хөгжлийн сан"-гийн санхүүгийн болон шилэн дансны үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

"Сүмбэр сумын Орон нутгийн хөгжлийн сан" нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлалтай гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 359,441.5 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 3,594.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70.0 хувиар буюу 2,516.1 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

"Сүмбэр сумын орон нутгийн хөгжлийн сан"-гийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 18,103.1 мянган төгрөгөөр буюу 0.9 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, Засгийн газрын оролцоо дансад материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	142,856.5	142,643.3	-213.2
Авлага	6,250.0	0.0	-6,250.0
Урьдчилгаа	0.0	0.0	0.0
Бараа материал	0.0	0.0	0.0
Үндсэн хөрөнгө	0.0	0.0	0.0
<b>Нийт хөрөнгө</b>	<b>149,106.5</b>	<b>142,643.3</b>	<b>-6,463.2</b>
Өр төлбөр	0.0	0.0	0.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	149,106.5	142,643.3	-6,463.2
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>149,106.5</b>	<b>142,643.3</b>	<b>-6,463.2</b>

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 142,643.3 мянган төгрөг болж 213.2 мянган төгрөгөөр буурсан нь шалтгаалжээ.

Авлага данс үлдэгдэлгүй болж 6,250.0 мянган төгрөгөөр буурсан нь барьцаа дансанд шилжүүлсэн авлага барагдсанаас шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 142,643.3 мянган төгрөг болж 6,463.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

"Сүмбэр сумын орон нутгийн хөгжлийн сан"-гийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 68,713.1 мянган төгрөгөөр буюу 15.2 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс ОНХНС-гийн санхүүжилт дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Нийт зардал өмнөх оноос 166,840.1 мянган төгрөгөөр буюу 46.4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал шилжүүлсний зардал байна.

Өмчийн өөрчлөлтийн тайланд өөрчлөлт ороогүй байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Төсвийг төлөвлөдөггүй ба сумын ИТХ-аар хэлэлцүүлж дараа онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг баталдаг байна. Сүмбэр сумын ИТХ-ын 2020 оны 07, 2021 оны 03 дугаар тогтоолоор шилжих хөрөнгө оруулалт 90,000.0 мянга, шинээр эхлэх 7 хөрөнгө оруулалтад 225,962.7 мянга, бараа, тоног төхөөрөмж 123,000.0 мянга, 5 их засварт 122,500.0 мянга, 5 хөтөлбөр, арга хэмжээнд 90,089.8 мянга, суурь зардалд 8,266.0 мянга, нийт 659,818.5 мянган төгрөгийг баталсан байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх "70503-орон нутгийн зорилтот хөрөнгө оруулалт" хөтөлбөрийн "80918-бусад", "82203-нийтийн эзэмшлийн гудамж талбайн гэрэлтүүлэг", "83112-хөтөлбөр төслийн дотоод урсгал зардал" арга хэмжээг санхүүжүүлэхээр 465,226.6 мянган төгрөгийн төсөв баталснаас орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих 244,818.5 мянга, орон нутгийн төсвөөс 275,000.0 мянга, 2020 оны үлдэгдлээс 140,000.0 мянга, нийт 659,818.5 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 244,818.5 мянга, орон нутгийн төсвөөс 275,000.0 мянга, урьд оны үлдэгдлээс 140,000.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээнд 520,031.6 мянган төгрөгийг зарцуулж, 142,643.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 520,031.6 мянган төгрөг буюу 78.8 хувьтай байгаа нь хийгдээгүй хөрөнгө оруулалт, их засварын ажил 114,962.7 мянга, нийт хөрөнгө

оруулалтаас гэрээний хэмнэлт 20,215.8 мянга, хөтөлбөр, төсөл арга хэмжээний хэмнэлт 4,608.3 мянган төгрөг байна.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

"Сүмбэр сумын Орон нутгийн хөгжлийн сан" нь нэмэлт санхүүжилтийн дансгүй байна.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Аудитаар Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108, А/111 дүгээр тушаалаар батлагдсан ерөнхий чиглэлд тусгагдсан асуудлыг онцлон авч үзсэн.

#### 3.8 Аудитын гол асуудал

Аудитад нөлөө үзүүлэх онцлох асуудал байхгүй байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

"Сүмбэр сумын Орон нутгийн хөгжлийн сан" нь 2021 онд нийт 530,515.1 мянган төгрөгийн 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 2,018.5 мянган төгрөгийн 4 мэдээллийг ил тод байршуулаагүй, мэдээлсэн боловч нийлүүлэгчийн нэр хаягийг дутуу мэдээлсэн зөрчилтэй байна.

Иймд дээрх зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага өгч ажиллалаа.

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

#### 3.9 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 82,273.7 мянган төгрөгийн 5 алдаа зөрчил, илэрснээс, 6,258.7 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, 63,055.0 мянган төгрөгийн

**"Сүмбэр сумын Орон нутгийн хөгжлийн сан"-гийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

1 зөрчилд зөрчлийг арилгах 1 албан шаардлага, 12,960.0 мянган төгрөгийн 2 зөрчилд 2 зөвлөмж өгсөн бөгөөд төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт 100.0%-тай байна.

*Хүснэгт 2 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт*  
/мянган.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-	-	-
Албан шаардлага	1	63,055.0	1	63,055.0	-	-	-
Зөвлөмж	2	12,960.0	2	12,960.0	-	-	-
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>76,015.0</b>	<b>3</b>	<b>76,015.0</b>			

**3.10 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

"Сүмбэр сумын Орон нутгийн хөгжлийн сан"-д анхаарах асуудал байхгүй байна.

**4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 33,212.8 мянган төгрөгийн 2 алдаа зөрчил илэрснээс 2,018.5 мянган төгрөгийн 1 зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 31,194.4 мянган төгрөгийн 1 зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

**4.1 Залруулсан алдаа**

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын залруулга хийгдээгүй байна.

**4.2 Төлбөрийн акт**

Төлбөрийн акт тогтоогдоогүй байна.

**4.3 Албан шаардлага**

**4.3.1 Шилэн дансны цахим хуудсанд таван сая төгрөгөөс дээш худалдан авалтыг мэдээлсэн боловч нийлүүлэгчийн нэр хаягийг мэдээлээгүй, хөрөнгө зарцуулахтай холбоотой 4 тушаал шийдвэр мэдээлээгүй** нийт 2,018.5 мянган төгрөгийн зөрчил нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.4, 6.4.8, 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.3, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын 2 дугаар зүйлийн 2.2.2.5, 2.2.3.2, 3 дугаар зүйлийн 3.1.7, 3.2.9 дахь заалтуудыг тус тус зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны 95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11-т заасны дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

#### **4.4 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### **1. Зардлын данстай холбоотой асуудал**

###### **1.1. Илрүүлэлт:**

Зарлагын гүйлгээг татварын цахим бүртгэлийн системээр шивэгдсэн эсэхийг тулгаагүй нийт 31,194.4 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.4, Сангийн сайдын 2017 оны 347-р тушаалаар батлагдсан журмын 6 дугаар зүйлийн 6.5 дахь заалтуудыг зөрчсөн, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангаж ажиллаагүй тул

###### **1.2. Өгсөн зөвлөмж:**

Зарлагын гүйлгээг татварын цахим бүртгэлийн системээр сар бүр тулгах

Дээрх төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/мян төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Сүмбэр сумын ОНХС	2	33,212.8	-	-	-	-	1	2,018.5	1	31,194.4



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 53/А0870275

Чойр

ТСА-2022/04/СГА-ТМС.

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Сүмбэр сумын "Орон нутгийн хөгжлийн сан" гийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Шилэн дансны цахим хуудсанд таван сая төгрөгөөс дээш худалдан авалтыг мэдээлсэн боловч нийлүүлэгчийн нэр хаяг дутуу, хөрөнгө зарцуулахтай холбоотой 4 тушаал шийдвэр мэдээлээгүй, нийт 2,018.5 мянган төгрөгийн зөрчил илэрсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" 6 дугаар зүйлийн 6.4.4-т "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", 6.4.8-т "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр", 7 дугаар зүйлийн 7.1.1-т "Засгийн газрын бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага, худалдан авах үйл ажиллагаатай холбоотой аливаа шийдвэр гаргасан, гарын үсэг зурсан эрх бүхий албан тушаалтан", 7.1.3-т "тухайн зарлага, төлбөрийн даалгаварт нэгдүгээр, хоёрдугаар гарын үсэг зурж гүйлгээ хийсэн албан тушаалтан", Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын 2 дугаар зүйлийн 2.2.2.5-т "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", 2.2.3.2-т "зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр", 3 дугаар зүйлийн 3.1.7-д "зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл болон төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулсан гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулсан, өр авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг гарсан өдрөөс хойш 7 хоногийн дотор энэ журмын 10 дугаар хавсралтад заасан маягтын дагуу PDF форматаар", 3.2.9-т "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээг гэрээ, хэлцэл, санхүүжилт өгснөөс хойш 7 хоногийн дотор энэ журмын 8 дугаар хавсралтад заасан маягтын дагуу цахимаар" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Захиргааны ерөнхий хуулийн 4 дүгээр зүйл, Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ

002040311



биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1-т "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана.", 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны цахим хуудсанд таван сая төгрөгөөс дээш худалдан авалтыг мэдээлсэн боловч нийлүүлэгчийн нэр хаягийг дутуу, хөрөнгө зарцуулахтай холбоотой 4 тушаал шийдвэр мэдээлээгүй нийт 2,018,500.00 төгрөгийн зөрчлийг нөхөн мэдээлэх, биелэлтийг 2022 оны 04 дүгээр сарын 25-ны дотор Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газар<sup>1</sup>т ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Сүмбэр сумын Засаг дарга Т.Бат-Эрдэнэ, нягтлан бодогч Б.Болор-Эрдэнэ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТОР *Анхтуяа* Б.АНХТУЯА  
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *Болор-Эрдэнэ* Б.САРАНТУЯА



<sup>1</sup> Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, Найрамдал хотхон, АЗДТГ-ын байр, Утас:70543156



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг  
Утас/Факс: 976-7054 3179  
И-мэйл: govsummer@audit.gov.mn

2022.03.24 № 112  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**СҮМБЭР СУМЫН ТӨСВИЙН  
ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ Т.БАТ-ЭРДЭНЭ  
ТАНАА**

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2022 оны А/12 дугаар тушаал, Төрийн аудитын байгууллагын 2022 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Сүмбэр сумын "Орон нутгийн хөгжлийн сан"-гийн 2021 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, тайланг албан шаардлага, зөвлөмжийн хамт хүргүүлж байна.

Аудитын тайланд тусгагдсан алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, төсөв, санхүүгийн сахилга бат, хариуцлагыг сайжруулах, дотоод хяналтын үр нөлөөг дээшлүүлэхэд анхаарч ажиллах, аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлж, биелэлтийг 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор гаргаж ирүүлэхийг зөвлөж байна.

Хавсралт 16 хуудастай

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.САРАНТУЯА

008020223

ААБ 6.5: АУДИТААР ИЛРҮҮЛСЭН АЛДАА, ЗӨРЧИЛТЭЙ АСУУДЛЫН БҮРТЭЛ

Байгууллагын нэр: Сүмбэр сумын Орон нутгийн хөгжлийн сан

Тайланг хугацаа: 2021.01-2021.12.31

№	Ажил гүйцэтгэний ангил, дансны үлдэгдэл, тодруулга	1	2	3	4	5	6	7	8	Төлгөөлөр /	
										Шалгалдагч байгууллагын хэлбэрдэх хүний	Овог нэр
А										9	10
1	Шилэн данс			Шилэн дансны цахим хуудсанд таван сая төгрөгөөс дээш худалдан авалтыг мэдээлсэн боловч нийлүүлэгчийн нэр хаагийг мэдээлээгүй, хөрөнгө зарцуулахтай холбоотой 4 тушаал шийдвэр мэдээлээгүй	2,016,500.0	Албан шаардлага өгөх	Зөвшөөрсөн		Албан шаардлага өгөх	Данса, нөглөн бодоч	Т.Бат-Эрдэнэ, Б.Болор-Эрдэнэ
2	Нийт зардал			Зарлалын гүйцэтгэлтэй татварын цахим бүртгэлийн системээр шилэгдсэн эсхийг тулгалгүй /	31,194,377.0	Зөвлөмж өгөх	Зөвшөөрсөн		Зөвлөмж өгөх	Дарга, нөглөн бодоч	Т.Бат-Эрдэнэ, Б.Болор-Эрдэнэ
				<b>Нийт алдаа, зөрчлийн дүн</b>	<b>33,212,877.0</b>						

Бэлтгэсэн: Аудитор  
Хянасан: Аудитын менежер  
Хянасан: Дарга, Төргүүлэх аудитор

Д/БХИХУА / Огноо: 2022.02.25  
Л/Наранбар / Огноо: 2022.02.25  
Т/Б.Сарантуяа / Огноо: 2022.02.25

4217144454  
УСАО055 9019049

Тангилцагч зөвшөөрч  
Сүмбэр сумын Засаг дарга  
Нөглөн бодоч  
Огноо: 2022.02.25